



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/88

Улаанбаатар хот

Тэмцээн зохион байгуулах тухай

Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.2.45 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, 16.5.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Онцгой байдлын байгууллагын 2019 оны Гал унтраах техникийн олон төрөлт спортын "Бүсийн аварга" шалгаруулах тэмцээнийг Улаанбаатар хот, Булган, Өвөрхангай, Дорнод, Баян-Өлгий аймгуудад 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 06 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Гал унтраах техникийн олон төрөлт спортын 2019 оны Бүсийн аварга шалгаруулах тэмцээний удирдамжийг нэгдүгээр, тэмцээнд оролцох багуудын жагсаалтыг хоёрдугаар, шүүгчдийн бүрэлдэхүүнийг гуравдугаар, тэмцээний хөтөлбөрийг дөрөвдүгээр, тэмцээнд шаардагдах зардлыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээний бэлтгэлийг бүрэн хангуулан, холбогдох дүрэм, заавар, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, дэг журам, сахилга баттай зохион байгуулахыг Гал түймэртэй тэмцэх газар (хурандаа Ц.Нямбаяр)-д үүрэг болгосугай.

4. Тэмцээнд шаардагдах зардал 5100000 /таван сая нэг зуун мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газар (дэд хурандаа Я.Гантөмөр)-т зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (бригадын генерал Г.Ариунбуян)-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Т.БАДРАЛ

00000763

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2019 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн
А/88 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ГАЛ УНТРААХ ТЕХНИКИЙН
ОЛОН ТӨРӨЛТ СПОРТЫН 2019 ОНЫ "БҮСИЙН АВАРГА"
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

Нэг: Тэмцээний зорилго.

Онцгой байдлын байгууллагын Гал унтраах техникийн олон төрөлт спортыг хөгжүүлэх, олон улсын тэмцээний түвшинд хүргэх, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, авхаалж самбаа, бие бялдрыг хөгжүүлэх, тэсвэр хатуужил олгох, албаны бэлтгэл бэлэн байдлыг хангах, Онцгой байдлын албыг иргэд, олон нийтэд сурталчилах, унтраах техникийн олон төрөл спортоор хичээллэх албан хаагчдын тоог нэмэгдүүлэх.

Хоёр: Тэмцээн явуулах хугацаа газар.

Гал унтраах техникийн олон төрөлт спортын Бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 06 дугаар сарын 05-ны өдрүүдэд Улаанбаатар хот, Булган, Өвөрхангай, Дорнод, Баян-Өлгий аймгуудад тус тус зохион байгуулагдана.

Гурав: Оролцох байгууллага, тамирчид.

Гал унтраах техникийн олон төрөлт спортын 2019 оны Бүсийн аварга шалгаруулах тэмцээнд Улаанбаатар бүсийн "Гандуулга" клубын 14 баг, Хууль сахиулах их сургуулийн Онцгой байдлын сургууль, Улаанбаатар төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын алба, Зүүн бүсийн "Шонхор" клубын 12 баг, Хойд бүсийн "Алтангадас" клубын 16 баг, Төвийн бүсийн "Од" клубын 10 баг, Баруун бүсийн "Алтайн бүргэд" клубын 10 баг нийт 64 багийн 512 тамирчид оролцоно.

Дөрөв: Оролцогч багуудад тавигдах шаардлага.

Спортын хэрэгсэл, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага, хэмжээ, тэдгээрийн найдвартай байдлыг бүрэн хариуцаж баг, тамирчдын өмсгөл, багийн мэдүүлэг зэргийг Гал унтраах техникийн олон төрөлт спортын дүрэмд зааснаар бэлтгэх ба баг тус бүр тамирчдаа орон нутагтаа эмчийн үзлэгт бүрэн хамруулан дүгнэлт гаргуулж, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч баталгаажуулсан байна.

Тэмцээнд оролцох баг 1 дасгалжуулагч, 8 тамирчинтай байна. Дасгалжуулагч, баг, тамирчид ижил өнгийн хувцсаар жигдэрч өөрсдийн клубын тугийг тэмцээний нээлт болон хаалтын ажиллагаанд барьж жагсана.

**Тав: Тамирчдыг хүлээн авах, байрлуулахтай
холбогдсон санхүү, аж ахуйн асуудал.**

Бүсийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг, тамирчдын ирэх, буцах унаа, тэмцээний өмнөх хоолны зардал, байрлах байрыг тухайн газар, хэлтсүүд өөрсдөө, шүүгчийн зардал болон тэмцээний шагнал, тэмцээн явагдах үеийн тамирчдын байрлах байр, хоолны зардлыг тэмцээн хариуцан зохион байгуулж байгаа газар, хэлтсүүд, тэмцээний шилжин явах цом, медаль, өргөмжлөлийг Онцгой байдлын ерөнхий газар хариуцна.

Зургаа: Тэмцээний үеийн зарим зохион байгуулалтын талаар

Тэмцээнд оролцохоор ирсэн баг тамирчдын сахилга бат, дэг журмыг хариуцан ёс журмын эргүүл томилох

Тэмцээнд оролцох багууд хаягийг 300х400 мм-ийн хэмжээтэй, өгөгдсөн загвараар хийж ирнэ.

Хаяг нь өгөгдсөн хэмжээнд гүн цэнхэр өнгийн хүрээтэй, цагаан дэвсгэртэй иш нь 30 см урттай байна. Онцгой байдлын албаны лого нь дээд хүрээнээс 2,5 см зайтай 9 см-ийн өндөртэй байх бөгөөд лого аймгийн нэр хооронд 2,5 см, үсэгний өндөр 2,5 см мөр хоорондын зай 1,5 см байна. Үсэг нь /Arial/ фондоор бичигдэнэ.

Загвар



Техник хэрэгслийн шүүгч томилох ба байлдааны тархалтын тэмцээний мэргэ онох цоргоны найдвартай хэвийн ажиллагааг хангуулна.

Тэмцээн зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан Улсын аварга шалгаруулах тэмцээн, албаны спорт, Онцгой байдлын албаны үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах

6.1. Довтолгооны шат болон саадтай 100 м-ийн тэмцээний төрөлд

Довтолгооны шатны тэмцээн явагдах цамхаг стандартын шаардлага хангасан бат бөх, хамгаалалтын тортой байх

Довтолгооны шат болон саадтай 100 м-ийн тэмцээний гараанд гарах болон бэлтгэл гарааны тамирчид суух сандал, шат байрлуулах тусгай талбайтай байх

Үзэгчдийг гүйлтийн замаас тусгаарласан хязгаарлалтын туузтай байх

Гүйлтийн зам бүр дээр хөлийн тулгуур урьдчилан байрлуулах

Шигшээ тамирчдын гүйлтийг шийдвэрлэх сугалааг урьдчилан бэлтгэсэн байх

6.2. 4x100 метрийн буухиа гүйлтийн тэмцээний төрөлд

Гараанд гарах багийн тоогоор шатах бодис, шингэнийг ГУТОТС-ын дүрэмд заасан хэмжээгээр жигд савлаж дугаарлан урьдчилан бэлтгэсэн байх

4-р замын хэсэгт туслахаар ажиллах албан хаагчидад аюулгүй ажиллагааны болон гүйцэтгэх үүргийн талаар тодорхой заавар, зөвлөмж өгсөн байх

Зам хоорондын хушуу дамжуулах болон хяналтын зурвасны харалдаа улаан, хөх өнгийн дарцагаар давхар тэмдэглэх

Гарааны болон замын, барианы, цагчин шүүгчдэд хэрэглэгдэх улаан, хөх өнгийн туг хүрэлцэхүйц бэлтгэх

6.3. Байлдааны тархалтын тэмцээний төрөлд

Байлдааны тархалтын тэмцээнд багийн мэдүүлэгт бичигдсэн тамирчдаас зөвхөн 7 тамирчин нь оролцоно. Баг тамирчид тэмцээний дүрэм, шүүгчийн шаардлагыг бүрэн ойлгосон, тэмцээнд хэрэглэгдэх багаж техник, тоног

төхөөрөмжийн бүрэн бүтэн, найдвартай ажиллагаа, шаардагдах хэмжээг бүрэн хангасан байна.

Долоо: Техникийн зөвлөгөөн хийх тухай

Гал унтраах техникийн олон төрөлт спортын 2019 оны Бүсийн аварга шалгаруулах тэмцээний техникийн зөвлөлгөөнийг тэмцээн эхлэхээс 1-2 хоногийн өмнө хийнэ.

Тэмцээнд оролцох багууд техникийн зөвлөгөөнд дүрэмд зааснаар мэдүүлэг, эмчийн гаргасан дүгнэлт, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч танилцсан болон хамгаалалтгүй гүйх талаар гаргасан баталгаа, тамирчдын офицер, ахлагчийн үнэмлэх, тухайн алба хаагчийн ажилд томилогдсон тушаалын хуулбар 2 хувь зураг зэргийг бүрдүүлэн авчирна.

Тухайн багийн тамирчид нь тэмцээнд эрх авсан Гал түймэр унтраах ангийн албан хаагч байх ёстой ба 3 сараас доошгүй хугацааны өмнө томилогдсон байна.

Найм: Дүн гаргах тухай

8.1. Довтолгооны шат болон саадтай 100 м-ийн тэмцээний дүн гаргах:

Хувийн болон багийн тэмцээний дүнг гаргахдаа тамирчдын тэмцээний төрөлд гаргасан хамгийн сайн амжилтыг авч цуваагаар байр эзлүүлнэ.

Довтолгооны шатны болон саадтай 100 метрийн төрлийн тэмцээний багийн дүнг гаргахдаа тухайн багийн 6 тамирчны гүйсэн хоёр оролдлогын дээд амжилтыг бүртгэн авч нийлбэр дүнгээр гаргана.

Хэрэв хоёр багийн амжилтын нийлбэр дүн тэнцсэн тохиолдолд гараанд гарсан дарааллаар байр эзлүүлнэ.

Дутуу бүрэлдэхүүнтэй оролцсон багийг гүйцэд оролцсон багийн дараа байр эзлүүлнэ.

Хэрэв хоёр болон хэд хэдэн баг ижилхэн буюу дутуу бүрэлдэхүүнтэй оролцсон бол амжилтын дарааллаар, цаашдаа адилхан байвал сугалааны дарааллаар байр эзлүүлнэ.

Шигшээ гүйлт: Саадтай 100 метрийн гүйлт болон довтолгооны шатны төрөлд дээд амжилт үзүүлсэн эхний 8 тамирчныг хагас шигшээ, хагас шигшээгээс амжилтаараа тэргүүлсэн 4 тамирчныг шигшээ гүйлтэд сонгон шалгаруулж үзүүлсэн амжилтаар нь байр эзлүүлнэ.

Хагас шигшээ болон шигшээ гүйлтийн амжилт нь багийн дүнд орохгүй. Эхний 8-д шалгарсан тамирчдыг үзүүлсэн амжилтаар нь эхний 4, дараагийн 4 гэж 2 хуваан урьдчилан бэлтгэсэн сугалаагаар гүйлтийн замыг тодорхойлж дасгалыг гүйцэтгүүлнэ.

Хагас шигшээд үзүүлсэн амжилтаараа эхний 4-т шалгарсан тамирчдыг дахин сонгон шалгаруулж дээд амжилт үзүүлсэн тамирчнаас гүйлтийн замыг сонгуулах ба дараагийн тамирчид дарааллаараа зам дагаж хувиарлагдана. Шигшээ гүйлтэд үзүүлсэн амжилт нь уг тамирчдын хувийн амжилтын үр дүн байна. Шигшээ гүйлтэд эхний 4 байрыг шалгаруулна.

Довтолгооны шатны тэмцээний хэрэгсэлд тавигдах шаардлага:

а/Довтолгооны шатны арааны урт нь 40 см-ээс богиногүй, арааны холбоос хэсэг 6 см-ээс багагүй, араа бэхэлгээнд байрлах хэсэг 90 градус, арааны шүд 8-аас доошгүй, жин 8.5 кг-аас багагүй, гуя хоорондын хэмжээ 30 см-ээс багагүй өргөнтэй, арааны шүд 1,5-2,0 см өндөртэй ямар нэг гэмтэлгүй бүрэн бүтэн байна.

б/Шатны араа, хөндлийн бэхэлгээ заавал хийгдсэн байна.

в/Шатыг хөнгөлөх зорилгоор хийц материалын, бат бөх чанарыг алдагдуулахыг хориглоно

Саадтай 100 метрийн тэмцээний техник хэрэгсэлд тавигдах шаардлага:

а/Хоолой нь 51 мм-н, урт нь тус бүр 20 метрээс багагүй, хүнд 5 кг-аас доошгүй байна;

б/Салаа билчир нь дүрмийн шаардлагад нийцсэн хөлтэй байж болох ба салаа билчирийн хоёр талын 51 мм-н 2 тотго нь крантгүй байж болно. Харин дунд талын тотго заавал кранттай байна. Салаа билчирийн тотго нь газрын түвшингөөс 6 см-ээс илүүгүй өндөрт байрлаж ямар нэг засваргүй, дээшээ, доошоо хазайлтгүй 90 градусын өнцөгтэй байна.

в/ Хушууны урт 32 см, жин нь 40 гр-аас багагүй, оосорны урт нь 40 см-ээс уртгүй байна.

г/Саадтай 100 метрийн тэмцээний төрөлд зөвхөн 3 хумстай тотгоор оролцохыг зөвшөөрнө.

д/ Хоолойг газарт тогтоох зорилгоор ямар нэг суурь ашиглахыг хориглоно. Мөн хоолойн голд өөр төрлийн нэмэлт зүйлээр /сангийн хоолой г.м/ өндөрлөхийг хориглоно. Харин хоолойд өөрт нь тогтоогч хийсэн байхыг зөвшөөрнө.

8.2. Хоёр төрөлтийн тэмцээний дүн гаргах:

Хоёр төрөлтийн тэмцээний ялагчийг довтолгооны шат, саадтай 100 м-ийн үндсэн хоёр оролдлогын үзүүлсэн дээд амжилтын нийлбэрээр шалгаруулна.

Тамирчдын үзүүлсэн амжилт ижил байвал довтолгооны шатны тэмцээний төрөлд үзүүлсэн дээд амжилт нь эхний байрт шалгарах үндэслэл болно. Хоёр төрөлтийн тэмцээний дүнг багийн амжилтад тооцохгүй.

8.3. 4x100 метрийн буухиа гүйлтийн тэмцээний дүн гаргах:

4x100 метрийн буухиа уралдааны төрөлд баг тус бүрээс дөрөв, дөрвөн хүний бүрэлдэхүүнтэй хоёр баг оролцох бөгөөд хамгийн сайн амжилт үзүүлсэн нэг багийн амжилтыг авч дэс дарааллаар байр эзлүүлнэ. Хэрэв ижил амжилттай байвал түрүүлж гараанд гарсан багийг шалгаруулна.

4x100 метрийн буухиа тэмцээний хэрэгсэлд тавигдах шаардлага:

а/ Эвхдэг болон эвхдэггүй, модон болон төмөр хийцтэй шат нь 3100 мм-ийн урттай, 8 хөндөлтэй, 30 см-ээс багагүй өргөнтэй 8,5 кг-аас багагүй жинтэй байна.

б/ Тэмцээн зохион байгуулагч талаас 5±1 кг жинтэй гал унтраагуур, 2 литр түлш, 0,25 литр /А-80/ бензиныг бэлтгэн савлаж дугаарласан байх ба сугалаагаар олгоно.

в/4-р замын тамирчидад заавал хөдөлмөр хамгааллын под каск, нүүрэвч, бээлийтэй байхыг шаардана.

8.4. Байлдааны тархалтын тэмцээний дүн гаргах:

Байлдааны тархалтын тэмцээнд багийн мэдүүлэгт бичигдсэн тамирчдаас зөвхөн 7 тамирчин оролцох бөгөөд сугалааны дарааллаар 2 оролдлогыг гүйцэтгэнэ.

Тэмцээнд хамгийн сайн амжилтыг үзүүлсэн дэс дарааллаар байр эзлүүлнэ. Хэрэв амжилт адилхан байвал гараанд гарсан дарааллаар байр эзлүүлнэ.

Байлдааны тархалтын тэмцээнд тавигдах шаардлага:

а/Байлдааны тархалтын төрөлд багууд "Гейзэр" мотопомпоор оролцох ба тамирчид өөрийн гүйцэтгэх даалгавар, багаж хэрэгслийг тавцанд дүрмийн дагуу

байрлуулж 10 метрийн зайд урьдчилан тэмдэглэсэн гарааны шугамын аль нэгийг сонгон бүгд нэг талаас гарна.

б/Гараанд гарахын өмнө багийн ахлагч гарааны шүүгчид багаж хэрэгслийн бэлэн байдлыг биечлэн шалгуулна.

в/Тэмцээнд хэрэглэх багаж тоног төхөөрөмжид хугацаа хожих зорилгоор ямар нэгэн засвар хийгдээгүй байна.

г/Гараанд гарах багийн бэлтгэл ажлын хугацаа 5 минутаас хэтрэхгүй байна.

д/Байлдааны тархалтын тэмцээнд хэрэглэгдэх хоолойны урт 19 м-ээс багагүй байна

е/Байлдааны тархалтын тэмцээний гараанд хаалттай, Б төрлийн 13 мм-ийн голчтой 2 хос /нийт 4 ширхэг/ хушууг урьдчилан сонгож баг бүр тухайн сонгосон хушуугаар цорго ононо.

Ес: Ерөнхий дүн гаргах:

Багийн ерөнхий дүнг гаргахдаа 4 төрлийн тэмцээний дүнг нэгтгэн хамгийн сайн амжилт үзүүлсэн амжилтаар нь цуваагаар байр эзлүүлэх ба оноо тэнцсэн тохиолдолд гарааны дарааллаар байр эзлүүлнэ.

-----oO-----

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2019 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн
А/88 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ГАЛ УНТРААХ ТЕХНИКИЙН ОЛОН ТӨРӨЛТ СПОРТЫН 2019 ОНЫ
БҮСИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ БАГУУД

д/д	Клубуудын нэр	Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн нэр	Гал унтраах ангийн дугаар
1	Улаанбаатар бүсийн "Гандуулга" клуб нийт 16 баг	Нийслэлийн Онцгой байдлын газар	10
			11
			14
			18
			26
			28
			29
			30
			34
			35
			63
			64
			65
			80
			ХСИСургууль
			УБТЗ-ын цэрэгжүүлсэн гал унтраах анги
2	Зүүн бүсийн "Шонхор" клуб нийт 12 баг	Говьсүмбэр	37
		Дорноговь	17/23/33
		Дорнод	52/53/62
		Сүхбаатар	15/47
		Хэнтий	32/49/42
3	Хойд бүсийн "Алтангадас" клуб нийт 16 баг	Булган	20/50
		Дархан-Уул	22/54/55
		Орхон	56/58/81/68
		Сэлэнгэ	19/36/40/61
4	Төвийн бүсийн "Од" клуб нийт 10 баг	Хөвсгөл	27/46/69
		Архангай	51
		Баянхонгор	16
		Дундговь	25
		Төв	24
		Өвөрхангай	12/45
		Өмнөговь	21/44/66/67
5	Баруун бүсийн "Алтайн бүргэд" клуб нийт 10 баг	Баян-Өлгий	31
		Говь-Алтай	59
		Завхан	39/43/57
		Ховд	38/48/70
		Увс	41/60
НИЙТ 64 БАГ 512 ТАМИРЧИН			

—oOo—

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2019 оны 15 дугаар сарын 26-ны өдрийн
А/88 дугаар тушаалын гуравдугаар хэвсрэлт

ГАЛ УНТРААХ ТЕХНИКИЙН ОЛОН ТӨРӨЛТ СПОРТЫН 2019 ОНЫ БҮСИЙН
АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН ЯВУУЛАХ ШҮҮГЧДИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

№	Шүүгчдийн гүйцэтгэх үүрэг	Тэмцээн зохион явуулах шүүгчийн нэр, цол	Албан тушаал	Бүсийн тэмцээн явагдах аймаг	Шүүгчийн зэрэг
1	Ерөнхий шүүгч	Хурандаа Ц.Нямбаяр	ГТТГ-ын дарга	Улаанбаатар бүс	Улсын шүүгч
	Нарийн бичиг шүүгч	Ахлах дэслэгч Э.Амгалан	ГТТГ-ын Мэргэжилтэн		Улсын шүүгч
	Шүүгч	Дэд хурандаа Н.Нямхорлоо	НОБГ-ын орлогч дарга		Улсын шүүгч
	Шүүгч	Хурандаа Д.Мөнхсайхан	НОБГ-ын Хэлтсийн дарга		1-р зэрэг
2	Ерөнхий шүүгч	Дэд хурандаа Г.Галбадрах	ГТТГ-ын Хэлтсийн дарга	Зүүн бүс Дорнод аймаг	Улсын шүүгч
	Нарийн бичиг шүүгч	Хошууч С.Галтзул	ГТТГ-ын мэргэжилтэн		1-р зэрэг
3	Ерөнхий шүүгч	Г.Баттөгс	ГУТОТСХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга	Төвийн бүс Өвөрхангай аймаг	Улсын шүүгч
	Нарийн бичиг шүүгч	Хошууч Н.Хишигбаатар	ГТТГ-ын ахлах мэргэжилтэн		1-р зэрэг
4	Ерөнхий шүүгч	Я.Ишжамц	ГУТОТСХ-ны ерөнхийлөгч	Баруун бүс Баян-Өлгий аймаг	Улсын шүүгч
	Нарийн бичиг шүүгч	Б.Батцэрэн	Бэлтгэл дэд хурандаа		-
5	Ерөнхий шүүгч	Ч.Цогтбаяр	ГУТОТСХ-ны УЗөвлөлийн гишүүн	Хойд бүс Булган аймаг	Улсын шүүгч
	Нарийн бичиг шүүгч	Хошууч П.Соронзонболд	ГТТГ-ын ахлах мэргэжилтэн		Улсын шүүгч

Жич: Цагчин шүүгч, эмч шүүгч, зам дундын шүүгч, гараа барианы шүүгч, техникийн шүүгч туслах шүүгч нарыг тэмцээн зохион байгуулж байгаа клубын тэргүүн, Онцгой байдлын даргын тушаалаар томилно.

—oOo—

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн
А/88 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

ГАЛ УНТРААХ ТЕХНИКИЙН ОЛОН ТӨРӨЛТ СПОРТЫН 2019 ОНЫ
БҮСИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨР

а/ 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдөр
Даваа гараг

12.00-14.00 Тэмцээний техникийн зөвлөгөөн зохион байгуулах, тэмцээн
зохион байгуулах талбай, хэрэгсэлд хэмжилт хийж баталгаажуулах
15.00-17.00 Шүүгч, тамирчид газартай танилцах

б/ 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдөр
Мягмар гараг

09.00-11.00 Довтолгооны шатны төрлийн тэмцээн
11.00-11.30 Довтолгооны шатны төрлийн тэмцээний хагас шигшээ,
шигшээ гүйлт
11.30-12.30 Үдийн завсарлага
12.30-13.30 Гал унтраах техникийн олон төрөлт спортын клубын
тамирчдыг сурталчилах, тэмцээний нээлтийн ажиллагаа
13.30-17.00 4x100 м-н буухиа төрлийн тэмцээн

в/ 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдөр
Лхагва гараг

09.00-11.30 Саадтай 100 м-н төрлийн тэмцээн
11.30-12.20 Саадтай 100 м-н төрлийн тэмцээний хагас шигшээ, шигшээ
гүйлт
12.20-14.00 Үдийн завсарлага
14.00- 17.30 Байлдааны тархалтын төрлийн тэмцээн
17.30-18.30 Шагнал гардуулах болон хаалтын ажиллагаа

---oOo---

МОНГОЛЫН ГАЛ УНТРААХ
ТЕХНИКИЙН ОЛОН ТӨРӨЛТ
СПОРТЫН ХОЛБОО



FIRE-FIGHTING
TECHNIQUES MULTIFOR
SPORTS ASSOCIATION
MONGOLIA

210644 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Партизаны гудамж утас 26-35-58, Гар утас 99148524.

Ulaanbaatar
E-mail: mail@emer.pmis.gov.mn
http://www.emer.pmis.gov.mn

2019.03.27. № 2
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛ, ДОРНОД, БАЯН-ӨЛГИЙ, БУЛГАН, ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ
БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА НАРТ

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны 03 дугаар 26-ны өдрийн А/88 дугаар тушаалаар Гал унтраах техникийн олон төрөлт спортын 2019 оны Бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг 2019 оны 06 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд зохион байгуулахаар батлагдсан.

Иймд тэмцээн зохион байгуулах Улаанбаатар хот, Булган, Өвөрхангай, Дорнод, Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын дарга нарт баг, тамирчдын мөнгөн шагнал, шүүгчийн зардлыг хавсралтын дагуу олгож, бэлтгэл ажлыг бүрэн ханган, амжилттай зохион байгуулахыг хүсье.

ГУТОТСХолбооноос тэмцээн зохион байгуулах газруудад зохих мөнгөн дэмжлэг үзүүлэх тул харилцах банкны дансыг ирүүлнэ үү.

Жич: Тэмцээнтэй холбоотой тодруулгыг ГУТОТСХолбооны ерөнхий нарийн бичгийн дарга Г.Баттөгсөөс тодруул. Утас: 99147653

Хавсралт 2 хуудас.

Хүндэтгэсэн,

МОНГОЛЫН ГУТОТС-ЫН ХОЛБООНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ Я.ИШЖАМЦ



ГАЛ УНТРААХ ТЕХНИКИЙН ОЛОН ТӨРӨЛТ СПОРТЫН 2019 ОНЫ
БҮСИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ШАГНАЛЫН ЗАРДАЛ

Довтолгооны шат			
1	Нэгдүгээр байр	Алтан медаль, өргөмжлөл	80.000 /1 хүн/
2	Хоёрдугаар байр	Мөнгөн медаль, өргөмжлөл	60.000 /1 хүн/
3	Гуравдугаар байр	Хүрэл медаль, өргөмжлөл	40.000 /1 хүн /
4	Гуравдугаар байр	Хүрэл медаль, өргөмжлөл	40.000 / 1 хүн /
Нийт дүн /төгрөг/			220.000 төг
Саадтай 100 метр			
1	Нэгдүгээр байр	Алтан медаль, өргөмжлөл	80.000 /1 хүн/
2	Хоёрдугаар байр	Мөнгөн медаль, өргөмжлөл	60.000 /1 хүн/
3	Гуравдугаар байр	Хүрэл медаль, өргөмжлөл	40.000 /1 хүн /
4	Гуравдугаар байр	Хүрэл медаль, өргөмжлөл	40.000 / 1 хүн /
Нийт дүн /төгрөг/			220.000 төг
Хоёр төрөлт			
1	Нэгдүгээр байр	Алтан медаль, өргөмжлөл	60.000 /1 хүн/
2	Хоёрдугаар байр	Мөнгөн медаль, өргөмжлөл	40.000 /1 хүн /
3	Гуравдугаар байр	Хүрэл медаль, өргөмжлөл	40.000 / 1 хүн /
Нийт дүн /төгрөг/			140.000 төг
4x 100 метрийн буухиа			
1	Нэгдүгээр байр	Алтан медаль, өргөмжлөл	200.000 /4 хүн /
2	Хоёрдугаар байр	Мөнгөн медаль, өргөмжлөл	160.000 /4 хүн /
3	Гуравдугаар байр	Хүрэл медаль, өргөмжлөл	120.000 /4 хүн /
Нийт дүн /төгрөг/			480.000 төг
Байлдааны тархалт			
1	Нэгдүгээр байр	Алтан медаль, өргөмжлөл	400.000 /8 хүн /
2	Хоёрдугаар байр	Мөнгөн медаль, өргөмжлөл	320.000 /8 хүн /
3	Гуравдугаар байр	Хүрэл медаль, өргөмжлөл	240.000 /8 хүн /
Нийт дүн /төгрөг/			960.000 төг
Багийн дүнгээр			
1	Нэгдүгээр байр	Алтан медаль, өргөмжлөл	800.000 / 1 баг /
2	Хоёрдугаар байр	Мөнгөн медаль, өргөмжлөл	600.000 / 1 баг /

3	Гуравдугаар байр	Хүрэл медаль, өргөмжлөл	400.000 / 1 баг /
Нийт дүн /төгрөг/			1.800.000 төг
Бүгд			3.820.000 төг

ШҮҮГЧДЭД ОЛГОХ ЗАРДАЛ

Монгол Улсын эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 2 дугаар сарын 18 ны өдрийн 53/45 дугаар тушаал, Тэмцээний санхүүжилт 4.4. Тэмцээнийг шүүсэн шүүгчдэд тэдний цол зэрэгтэй уялдуулан ажилласан өдөр тутам дор зааснаас доошгүй хөлсийг олгоно.

№	Шүүгчдийн гүйцэтгэх үүрэг	Нэг өдрийн хөлс
1	Олон улсын шүүгч	20 000
2	Улсын шүүгч	15 000
3	1-р зэргийн шүүгч	10 000
4	2-р зэргийн шүүгч	8 000
5	3-р зэргийн шүүгч	6 000
6	Туслах шүүгч	5 000

Жич: Тэмцээнд ажилласан их эмчийг улсын шүүгчтэй, бага эмчийг 1-р зэргийн шүүгчтэй адилтган үзнэ.

---oOo---